

**НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН  
ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ЭЦСИЙН  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ТАНИЛЦУУЛГА**

2023 оны 12 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан хуулийн төсөлд уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан иргэдийн эрүүл мэндийг эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зохицуулалтыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа иргэдийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх зорилгоор биеийн тамир, спортоор хичээллэх хөшүүрэг болгож эрүүл мэндийн даатгалаас тодорхой хөнгөлөлт, урамшуулал олгох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир хуулийн төсөл батлагдсанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийтээр дагаж мөрдөхөд эрүүл мэндийн байгууллагуудад суурь нөхцөл бүрдсэн эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авлаа.


Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 2 санал, анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэний дагуу мөн зүйлийн 42.2.3-т заасныг баримтлан зарчмын зөрүүтэй 1 саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Ж.ЧИНБҮРЭН**